



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/769

Булган сум

**Зудын эрсдэлээс хамгаалах ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд цагийн байдал хүндрэх болон зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд:

Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Ууганбаяр (Аймгийн Онцгой байдлын газрын

дэд дарга)

Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)

Э.Пүрэвдэмбэрэл ("Булган АЗЗА" ТӨХК-ийн


захирал)

Н.Баасанжаргал (Авто тээврийн үндэсний төв

ТӨҮГ-ын Булган аймаг дахь газрын дарга)

2. Мал аж ахуй болон төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн үед бэлэн байдлыг хангуулах орон нутаг дахь мэргэжлийн анги, албыг нэгдсэн удирдлагаар хангаж, бэлтгэл ажлыг бүрэн хангахыг ажлын хэсэг (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ